

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА НАРЫН 2023 ОНД ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 02 сарын 17-ны өдөр

Мандалговь хот

Нэг.Гэрээний агуулга, зорилго

1.1. Дундговь аймгийн Засаг дарга, **Орон нутгийн өмчийн газрын дарга** нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний зорилго нь шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, нутгийн захиргааны төрийн бүхий л байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, Монгол улсын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах чиглэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.2. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас **Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат**, нөгөө талаас **Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Адъяасүрэн** нар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж, 2 хувь үйлдэв.

1.3. Уг гэрээ болон гэрээний хавсралтаар **Дундговь аймгийн Засаг дарга** болон **Дундговь аймгийн Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын** харилцан хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ, түүний тоо хэмжээ, чанарт тавих шаардлага, гэрээний биелэлтийг дүгнэх бусад нөхцөлийг тусгав.

1.4. Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжуудтай нийцүүлэн зохицуулна.

1.5. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг /хавсралт/ байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх эрх, үүрэг

2.1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлнэ.

2.2. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлнэ.

2.3. Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж төрөөс иргэдэд үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, төсвийн үйл ажиллагааг ил тод болгоно.

2.4. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэл, аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

2.5. Төрийн бүх байгууллагад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага зохицуулалтаар хангана.

2.6. Нутгийн захиргааны байгууллагуудад чанарын менежментийн олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

2.7. Ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааны түвшин дээшлүүлэхэд нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг хангаж ажиллана.

2.8. Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.9. Агентлагийн дарга нарыг албан болон хувийн ажлаар гадаадад явах, удирдамж, хөтөлбөр, хүсэлттэй танилцаж, зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.10. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлэх, төрийн албаны сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гурав. Орон нутгийн өмчийн газрын даргын хүлээх үүрэг

3.1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг салбарын удирдлага, аймгийн Засаг даргын өмнө хариуцна.

3.2. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, салбарын болон аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилт, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж ажиллана.

3.3. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шударга, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй удирдан чиглүүлж, ажлын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгаж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.

3.4. Удирдах, удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод нээлттэй, авлигагүй шударга, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, хүнд суртлыг арилгах арга хэмжээ авч ажиллана.

3.5. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж ажиллана.

3.6. Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх, e-mongolia системийг иргэдэд сурталчлах, төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.7. Байгууллагын соёлыг нэвтрүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллана.

3.8. Сум байгууллага бүр хог хаягдлаа ангилан ялгах ажилд санаачилгатай ажиллах

3.9. Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэгч байгууллагууд (Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд)-д нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлнэ.

3.10. Тухайн байгууллагын албан ёсны фейсбүүк хуудсыг идэвхжүүлэх, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол оруулж хэвшинэ.

3.11. ISO стандартыг сумдад нэвтрүүлэх талаар үе шаттай ажлуудыг зохион байгуулна.

3.12. 2023 оныг аймгийн Засаг даргын захирамжаар "Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан ажлын төлөвлөгөөндөө зорилт арга хэмжээ тусган үр дүнтэй ажлуудыг зохион байгуулна.

3.13. Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших

3.14. Нээлттэй Дундговь хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.15. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авна.

3.16. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллана.

3.17. Шилэн данс, цахим мэдээллийн ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чанд баримтлан, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллана.

3.18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.19. Төрийн албан хаагчидтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг харгалзан дүгнэж, үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчидтай хариуцлага тооцож ажиллана.

3.20. Албаны болон хувийн ажлаар гадаадад явахдаа аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т мэдэгдэж, удирдамж хөтөлбөрөө батлуулан аймгийн Засаг даргаас зөвшөөрөл авч явна.

3.21. Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай, чанартай зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан дүгнэнэ.

Тав. Бусад зүйл


5.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана.

5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд урамшуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ


2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АДЪЯАСҮРЭН

2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр




Төлөөлөгөөг хянасан:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч
Ц.МӨНХБАТ
огноо

Төлөөлөгөө баталсан:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Тэмдэг



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв эх үүсвэр /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хугацаа /I-IV улирал/	Хариуцах албан хаагч
					Эхний хагас жилд	Жилийн эцэст		
	Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах, худалдан авах ажиллагааны тогтолцоонд техник технологи, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд хүний оролцоог багасгасан үйл ажиллагаа дэмжин ажиллах, Орон нутгийн өмчийн талаар бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлээр хяналт тавих.							
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
	Зорилт 1. Орон нутгийн өмчийн	19.1	Хөрөнгийн	80	40	90	I-IV улирал	Н.Гэрэлмаа

1	хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.		ашиглалтын хувь						
1.1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт тавих	ОНТ 8.2	Тухайн жилд хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо	141	-	142	III-IV улиралд	Н.Гэрэлмаа	
1.2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулан ашиглалтыг сайжруулах	-	Орлого төвлөрүүлэх хувь	95	40	97	I-IV улирал	Н.Гэрэлмаа	
1.3	Улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын зээл, тусламж хандив болон бусад эх үүсвэрээр хийгдсэн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх	-	Үндсэн хөрөнгийг бүртгэсэн хувь	95	70	100	I-IV улирал	Н.Гэрэлмаа	
1.4	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны хөрөнгийн тайланг хүлээн авах, улсын нэгтгэлд хамаруулах	-	Тайлан хүлээлгэн өгөх байгууллагын тоо	141	142	142	I улиралд	Н.Гэрэлмаа	
1.5	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн харилцааг хууль, журмын дагуу аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэх	-	Тухай жилд гарсан тогтоолын хэрэгжилтийн хувь	100	40	100	I-IV улирал	Н.Гэрэлмаа	
2	Зорилт 2. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2022 онд 34 байсныг 2023 онд 36 хувьд хүргэнэ.	-	Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь	34	15	36	I-IV улирал	Б.Адъяасүрэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа	
2.1	Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх		Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх	100	50	100	I-IV улирал	Б.Адъяасүрэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа	

		хувь	1	0	1	IV улирал	Б.Адъяасурэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
2.2	Орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм журам, цахим системийн ашиглалтын мэдлэг олгох, чадавхжуулах сургалт зохион байгуулах	Тухайн жилд зохион байгуулсан сургалтын тоо	1	0	1	IV улирал	Б.Адъяасурэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
2.3	Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлуулах, төлөвлөгөөг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэх	Жагсаалт батлагдаж, хүргүүлсэн хугацаа, нийтэлсэн байдал (тийм-1, үгүй-0)	1	1	1	I-улирал	Б.Адъяасурэн
2.4	Улсын болон орон нутгий төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сонгон шалгаруулах ажиллагааг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулах	Тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	2022 онд 75 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан	30 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан	Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 40 төсөл арга хэмжээ зохион байгуулна	I-IV улирал	Б.Адъяасурэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
2.5	Төрийн худалдан авах ажиллагаанд үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах	A3 сертификаттай иргэдийн нөөц нэмэгдүүлэх сургалтын тоо, A3 сертификат эзэмшигч иргэдийн тоо	2	0	1	II-улирал	Б.Адъяасурэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
			256	270	300	II-улирал	Б.Адъяасурэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
"ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
3	Зорилт 3. Байгууллагын соёлыг нэвтрүүлэх, удирдах удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод авлигагүй, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх	Ажил зохион байгуулсан байх Тийм -1 Үгүй- 0	0	1	1	I-IV улирал	Бүх албан хаагч

3.1	Ажлын байрны соёл буюу 5S зарчмыг хэрэгжүүлэх.	5S	5S зарчим хэрэгжүүлсэн байх Тийм -1 Үгүй- 0	0	0	1	I-IV улирал	Бүх албан хаагч
3.2	Ажлын байрны соёл буюу "5S зарчмыг хэрэгжүүлэх" сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгуулах		Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	0	0	7	I-IV улирал	Бүх албан хаагч
3.2	Нээлттэй дуудлага худалдааны зар болон үр дүнг иргэдэд ил тод нээлттэй хүргэж ажиллах.		Ил тод хүргэсэн мэдээллийн байдал хувь	50	0	100	I-IV улирал	Н.Гэрэлмаа
3.3	Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр, санхүүжүүлэгч байгуулагад төсөл бичиж хүргүүлэх.		Төсөл бичиж хүргүүлсэн тоо	1	0	1	I-IV улирал	Бүх албан хаагч
4	Зорилт 4. Нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар тарих модны тоог нэмэгдүүлнэ.		Нэмэгдүүлсэн модны тоо	77	157	165	II-IV улирал	Бүх албан хаагч
3.1	Төв зам дагуу тарьсан модны арчилгааг хийх		Ургалтын хувь	83	-	95	II-IV улирал	Бүх албан хаагч
3.2	Олон нийтийн газарт хог ангилан ялгах хогийн савтай болох		Хогийн савтай болсон эсэх Тийм -1 Үгүй- 0	2	1	1	I-IV улирал	Бүх албан хаагч
5	Зорилт 5. Цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх		Төндөрт оролцогчийн лавлагаа мэдээллийг түргэн шуурхай цахим системээр татсанаар хуурамч материал ирүүлсэн компаний тоо буурна.	5	0	0	I-IV улирал	Бүх албан хаагч
5.1	Байгууллагын албан ёсны фейсбүүк		Нэмэгдсэн эсэх	2000	2100	2200	I-IV улирал	Мэргэжилтэн

	аккаунтын дагагчийн тоог нэмэгдүүлэх		Тийм-1 Үгүй-0						М.Бат-Эрдэнэ
5.2	Тендер шалгаруулалтад оролцогч аж ахуй нэгжүүдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны "ХУР" систем болон цахим үйлчилгээний нэгдсэн портал "E-mongolia" системийг ашиглан шалгах ажлыг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх		Тендерт оролцогч аж ахуй нэгжүүдийн мэдээллийг "ХУР" болон "E-mongolia" системээс шалгадаг болсон эсэх	0	1	1		I-IV улирал	Б.Адъяасүрэн М.Бат-Эрдэнэ Б.Сайхантуяа
5.3	Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх		Тийм-1 Үгүй-0 системээс нэвтрүүлсэн эсэх	0	0	1		I-IV улирал	Бүх албан хаагч
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
6	Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших		хэрэгжилтийн тайланг БШУГ-т хүргүүлэх тоо / сар бүр/	03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн	5	5		I- IV	Бүх албан хаагч
7	Албан хаагчдад үндэсний бичгийн дунд шатны сургалтыг зохион байгуулж, батламж гардуулна.		Туршсан эсэх тийм -1, үгүй -0 Дунд шатны модуль сургалтад хамрагдаж батламжаа гардан авсан албан хаагчдын хувь	0	0	1		I- IV	Бүх албан хаагч
8	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг төрийн албаны мэрэгшүүлэх багц сургалтад хамруулах		Сургалтад хамрагдсан албан хаагчдын хамрагдалтын хувь өссөн байна	0	0	1		I-IV улирал	Б.Сайхантуяа

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний төрөл, хэлбэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр түвшин	Хугацаа / I-IV улирал/	Хариуцах албан хаагч
Нэг. “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, үр чавдар, санал санаачлагыг харгалзан, цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд”					
1	Албан хаагчид олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг хууль тогтоомжийн дагуу олгох.	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
2	Албан хаагчдын улиралын ажлын үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал олгох.	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
Хоёр. “Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, дэмжлэг, нөхөн олговор олгох”					
	Албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
	Албан хаагч хүүхэдтэй болох, шинэ гэр орон сууцанд ороход тусламж үзүүлэх	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
	Албан хаагчид сар бүр унаа, хоолны мөнгөн олговорын зохих хэсгийг олгох	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
	Төрийн албан хаагчид өвлийн улирлын бэлтгэлээ хангахад зориулж нөхөн төлбөр олгох	Олгосон эсэх Тийм-1 Үгүй-0	1	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаяа
	Ажилтан өөр газар шилжих, албан тушаал дэвшихэд	Олгосон эсэх			Газрын дарга Б.Адъяасүрэн

хүндэтгэл үзүүлэх	Тийм-1 Үгүй-0	1		Нягтлан бодогч Э.Саранзаа
Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээ хийлгэх, шаардлагатай ажилтануудыг тухай бүрт эмчилгээ сувилгаа хийлгэх витаминжуултад хамруулах зэрэг эрүүл мэндийн дэмжлэг туслалцаа үзүүлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	7	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаа
Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх	Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн байна Тийм-1 Үгүй-0	0	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаа
Спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, спортын арга хэмжээнд хамруулж, спорт, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх	Албан хаагчдын дунд спорт арга хэмжээ зохион байгуулагдсан тоо	0	I-IV улирал	Газрын дарга Б.Адъяасүрэн Нягтлан бодогч Э.Саранзаа

Төлөвлөгөө гаргасан:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
М.БАТ-ЭРДЭНЭ

Танилцсан:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.АДЪЯАСҮРЭН

